



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/620

Булган сум

┌ Хөгжимт жүжгийн театрын үйл ажиллагааны  
зардалд дэмжлэг үзүүлэх тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн цаг үеийн болон урлаг, соёлын зэрэг зохион байгуулалтын арга хэмжээнүүдэд идэвх санаачилгатай оролцсон тул Монгол Улсын Төрийн Соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, найруулагч Н.Наранбаатарын нэрэмжит Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын үйл ажиллагааны зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010862